

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Сургуулийн өмнөх боловсролын хэлтэс
2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсө в	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.6.	Сургуулийн өмнөх боловсролын салбарын эрх зүйн орчныг сайжруулах	-	-	-	-	-	Сургуулийн өмнөх боловсролын салбарын эрх зүйн орчныг сайжруулах зорилтын хүрээнд дараах 8 журам, дүрэм, шаардлагыг боловсруулах, батлуулахаар төлөвлөж хэрэгжилт 92,5 хувьтай байна. Үүнд: 1. Цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг шинэчлэн	90%	90%

						боловсруулж батлуулах -90 хувь 2. Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэг, хүүхдийн цэцэрлэгийн салбар бүлгийн орон тооны хязгаарын жишиг нормативын төсөл боловсруулж, батлуулна. -100 хувь 3. Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам шинэчлэн боловсруулж батлуулна.-100 хувь 4. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн арга зүйч, багшийн албан тушаалд тавигдах шаардлага, албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулж батлуулна.-70 хувь 5. Сургуулийн өмнөх боловсролын		
--	--	--	--	--	--	---	--	--

						байгууллагын үнэлгээний журмын төсөл боловсруулж батлуулна.-100 хувь 6. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийг үнэлэх журмын төслийг боловсруулж батлуулна.-90 хувь 7. Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах журмын төслийг боловсруулж батлуулна.-100 хувь 8. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагын төсөл боловсруулна.-90 хувь Сургуулийн өмнөх боловсролын салбарын эрх зүйн орчныг холбогдох хууль		
--	--	--	--	--	--	--	--	--

							болон шинэ зууны хүүхдийн хөгжлийн хэрэгцээ боловсролын шинэчлэл, шинэ сэргэлтийн бодлогын зорилго, зорилттой уялдуулан шинэчилснээр сургуулийн өмнөх боловсролд хүүхэд бүр тэгш хамрагдах, үйлчилгээний гадна хүүхдийг орхигдуулахгүй байх, сургалт үйл ажиллагааны чанарт ахиц гарч хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж нөхцөл бүрдэж байна.		
1.6.1	Цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг шинэчлэн боловсруулж батлуулах	-	Баримт бичгийн боловсруулалт	БСШУС-ын сайдын 2019 оны А/854 дүгээр тушаал	Цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	-	Журмын төслийг Able дотоод системд байршуулсан, батлагдах шатанд явж байна. Журмын төслийг 2024 оны 03 сарын 18-нд БШУЯ-ны БНБТГ, ЕББУЗГ-ийн бүрэлдэхүүнд,	90%	90%

							2024 оны 03 сарын 20-нд БШУЯ-СӨБХ, БЕГ, БСҮХ-ийн СӨБ хариуцсан мэргэжилтнүүд, БШУ-ны СӨБ-ын үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл, цэцэрлэгийн арга зүйч, багш нарын төлөөлөл оролцсон хэлэлцүүлэг зохион байгуулж саналуудыг тусган сайжруулсан. Хавсралт: 7 файл		
1.6.2	Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэг, хүүхдийн цэцэрлэгийн салбар бүлгийн орон тооны хязгаарын жишиг нормативын төсөл боловсруулж, батлуулна.	-	Баримт бичгийн боловсруулалт	Төсөл боловсруулж байна.	Төсөл боловсруулна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэг, хүүхдийн цэцэрлэгийн салбар бүлгийн орон тооны хязгаарын жишиг норматив батлуулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2024 оны 02 сарын 26-ны өдрийн "Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай" А/85, А/34 дүгээр хамтарсан тушаалаар батлуулсан. 2024-2025 оны хичээлийн жилээс тус "Орон тооны хязгаарын жишиг норматив батлах	100%	100%

						тухай” тушаалыг мөрдөж эхлэхтэй холбогдуулан БШУЯ-с Боловсролын ерөнхий газарт “Тушаалын хэрэгжилтийг хангах тухай” 2/1297 тоот албан бичгийг 2024 оны 04 сарын 03-ны өдрийн илгээж, төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгт энэхүү батлагдсан орон тооны хязгаарын жишиг нормативыг мөрдөж ажиллах урьдчилсан судалгаа хийж, гарах эрсдэлийг тооцон, хариу арга хэмжээ авах, орон нутагт хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах, ажлын гүйцэтгэл үр дүн, төсвийг үр ашигтай зарцуулахад хяналт тавих чиглэлээр орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн		
--	--	--	--	--	--	---	--	--

						байгууллагад зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, батлагдсан орон тооны хязгаарын жишиг нормативд үндэслэн цэцэрлэгийнхээ байршил, бүтэц, хүчин чадал, хүүхдийн тоог харгалзан хүний нөөцөө төлөвлөх чиглэлээр цэцэрлэгийн эрхлэгч нарт сургалт, зөвлөгөө өгөх, улсын хэмжээнд байршлаас үл хамааран адил хүчин чадалтай цэцэрлэгт ажиллаж буй ажилтнуудын орон тоо нормативыг баримтлан шаардлагатай зохицуулалт хийх арга хэмжээ авч 2024 оны 08 сарын 01-ний өдрийн дотор ирүүлэх чиглэл хүргэн ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	--	---	--	--

1.6.3	Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам шинэчлэн боловсруулж батлуулна.	-	Баримт бичгийн боловсруулалт	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаал	Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн а/115 дугаар тушаал “Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам” “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам” батлагдсан. Хавсралт: 1 файл	100%	100%
1.6.4	Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн арга зүйч, багшийн албан тушаалд тавигдах шаардлага, албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулж батлуулна.	-	Баримт бичгийн боловсруулалт	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 оны А/430 дугаар тушаал	Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн арга зүйч, багшийн албан тушаалд тавигдах шаардлага, албан тушаалын тодорхойлолтын төсөл боловсруулсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн арга зүйч, багшийн албан тушаалд тавигдах шаардлага, албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлуулсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн арга зүйч, багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагын төслийг боловсруулан 2024 оны 04 сарын 19-ний өдөр БШУЯ-ны 111 тоотод БНБТГ-ын шинжээч, ЕББУЗГ-ын дарга, СӨБХ-	70%	70%

							ийн дарга, мэргэжилтэн, МБТСГ-ын мэргэжилтэн, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн нарын хамт хэлэлцсэн. Арга зүйч, багшийн албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагын төслийг 2024 оны 06 сард Боловсрол, шинжлэх ухааны яамны сайт дээр байршуулан санал авахаар төлөвлөж байна. Хавсралт: 1 файл		
1.6.5	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үнэлгээний журмын төсөл боловсруулж батлуулна.	-	Баримт бичгийн боловсруулалт	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 оны А/803 дугаар тушаал	Төслийг боловсруулсан байна.	Журам батлагдсан байна.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үнэлгээний журмын төслийг 2024 оны 03 сарын 20-нд БШУЯ-СӨБХ, БЕГ, БСҮХ-ийн СӨБ хариуцсан мэргэжилтнүүд, БШУ-ны СӨБ-ын үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл, цэцэрлэгийн арга	100%	100%

							зүйч, багш нарын төлөөлөл оролцсон хэлэлцүүлэг зохион байгуулж саналуудыг тусгасан. Төслийг БШУЯ-ны Чанарын үнэлгээний хэлтсээс яамны олон нийт, хэлэлцүүлэг хэсэгт 2024 оны 03 сарын 12-ны өдөр байршуулан санал авч саналыг тусган, Able системд байршуулан хянагдах шатанд явж байна. Хавсралт: 3 файл		
1.6.2	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийг үнэлэх журмын төслийг боловсруулж батлуулна.	-	Батлагдсан журам	-	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийг үнэлэх журмын төслийг боловсруулж батлуулсан байна.	-	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийг үнэлэх журмын төслийг шинэчлэн боловсрууллаа. Хүүхдийн хөгжлийн үнэлгээ нь сургуулийн өмнөх боловсролын сургалт үйл	90%	90%

						ажиллагааны өмнө хийх "явцын үнэлгээ /гарааны оношлох үнэлгээ/", сургалт үйл ажиллагааны явц дунд хийх "явцын үнэлгээ", сургалт үйл ажиллагааны төгсгөлд хийх "үр дүнгийн үнэлгээ"-г хийж хүүхдийн хөгжилд гарч буй ахиц дэвшлийг илрүүлэн түүнд тохирсон хөгжлийн дэмжлэг үзүүлэхээр журамд тусгаад байна. Тус журмын төслийг батлуулахыг өмнөх хүчин төгөлдөр мөрдөж буй журмын зохицуулалтаас хамааран түр хойшлуулаад байна. Учир нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийн үнэлгээ болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээг хамтад		
--	--	--	--	--	--	--	--	--

						нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын /хуучнаар/ 2020 оны А/280 дугаар тушаалаар батлагдсан журмаар зохицуулж, журам хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль шинэчлэн батлагдаж, хуулийн 26.2-т "Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээгээр хүүхдийн сургуульд суралцахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тогтооно." гэж заасантай холбогдуулан сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг 2021-2023 онд зохион байгуулсан ажлын тайлан, үнэлгээний үр дүнд шинжилгээ		
--	--	--	--	--	--	--	--	--

							хийж, дагнасан журамаар зохицуулах шаардлага үүссэн бөгөөд тус үнэлгээний журмын боловсруулалтын үйл явцтай /Чанарын үнэлгээний хэлтсийн хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарч/ холбоотойгоор өмнөх журмыг хүчингүй болгох боломжгүй байгаа болно. Хавсралт: 1 файл		
1.6.2	Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах журмын төслийг боловсруулж батлуулна.	-	Батлагдсан журам	-	Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах журмын төслийг боловсруулж батлуулсан байна.	-	"Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах журам"-ын төслийг боловсруулан батлуулахаар able системд байршуулсан, хяналтын шатанд байна. Энэхүү журмын зорилго нь СӨБ-ын зорилго,	100%	100%

						сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад баримтална. Журмаар СӨБ-ын салбарт хэрэглэгдэж буй нэр томъёоны тайлбар болон нийтлэг зохицуулалт; үндсэн болон хувилбарт сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт; сургалтын орчин; эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг зохицууллаа. Журмын онцлог нь: 1. Бага насны хүүхдийн нийгэмшил, сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийг дэмжих сургалтыг бусад суралцахуйн чиглэлийн нэгэн адил төлөвлөж хэрэгжүүлэх; 2.		
--	--	--	--	--	--	---	--	--

						СӨБ-ын сургалт, үйл ажиллагааг “Бүлгийн менежмент” /шинэ нэр томьёо/ буюу сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх, хүүхэдтэй харилцах, тэдний оролцоог хангах, идэвхжүүлэх, сургалтын орчин бүрдүүлэх, бүлгийн өрөөний зохион байгуулалт хийх зэрэгт багш өөрийн онцлог бүхий арга, технологи боловсруулан харилцан уялдаатай төлөвлөж, хэрэгжүүлэх; 3. Хүүхдийн хөгжлийн ялгаатай байдал, суралцах арга барилд тохирсон ягаатай суралцахуйн арга барилыг ашиглаж хүүхэд бүрд тохирсон хөгжлийн дэмжлэг үзүүлэх; 4. Сургалтын орчныг		
--	--	--	--	--	--	--	--	--

						материаллаг орчноос гадна сэтгэл зүй, харилцааны ээлтэй орчин бүрдүүлэх; 5. СӨБ-ын түвшинд хүүхдийн суралцахуйн үйлийн онцлогоос шалтгаалан цахим сургалт, цахим хэрэглэгдэхүүнийг зохистой түвшинд ашиглах, цахим хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг тус тус тусгалаа. Энэхүү журмын төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж, 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 16/2013 дугаар албан бичгийг аймаг, нийслэлийн БШУГ, БСҮХ, БЕГ-т хүргүүлж ирүүлсэн саналыг тусган сайжруулалт хийж батлуулахад бэлэн болголоо. Журам батлагдсанаар		
--	--	--	--	--	--	--	--	--

							СӨБ-ын сургалт, үйл ажиллагаау олон улсын чиг хандлагад нийцүүлснээс гадна Монгол улсын хөгжлийн бодлого, нийгмийн эрэлт хэрэгцээ, хангахуйц сургалт, үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж байна.		
1.6.3	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагын төсөл боловсруулна.	-	Батлагдсан шаардлага	Шаардлагын төсөлд холбогдох судалгаа хийгдсэн	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагын төсөл боловсруулна	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн , тоглоом наадгайд тавих шаардлагын төсөл батуулсан байна.	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагын төслийг дараах бүтэцтэйгээр боловсрууллаа. Үүнд: 1. Хамрах хүрээ 2. Норматив ишлэл. 3. Нэр томъёоны тодорхойлолт. 4. Ерөнхий шаардлага. 5. Тусгай шаардлага. 6. Сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай. 7. Хүүхдийн цэцэрлэгийн ном гэсэн 7 агуулгын	90%	90%

						хүрээнд шалгуурыг боловсрууллаа. "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлага"-ын төслийг нийслэлийн БШУГ, дүүргийн БХ-ийн мэргэжилтэн, аймаг, нийслэлийн цэцэрлэгийн багш, арга зүйч, удирдах ажилтнуудын төлөөллөөс санал авч , сайжруулан, яамны харъяа Боловсролын судалгааны хүрээлэнд Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргын 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн "Санал авах тухай" 16/1847 тоот албан бичгээр хүргүүлэн, ирүүлсэн санал, зөвлөмжийг судлан дахин боловсруулалт		
--	--	--	--	--	--	---	--	--

							хийн ажиллаж байна. Сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай нь сургалтын хөтөлбөрийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг тул Засгийн газрын 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн "Үзэл баримтлал батлах тухай" 176 дугаар тогтоолоор батлагдсан сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, турших, хэрэгжүүлэх, төлөвлөгөөний арга хэмжээтэй "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлага"-ыг уялдаалан		
--	--	--	--	--	--	--	--	--	--

						ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
3.1.	Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөц, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын удирдлага зохицуулалтыг хангах	-	-	-	-	Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөц, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын удирдлага зохицуулалтыг хангах зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөн 83,3 хувьтай хэрэгжүүлж байна. Үүнд: 1. Нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн чадвар эзэмшүүлэх хөтөлбөрийн туршилт зохион байгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.- 100 хувь 2. Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөн туслах ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөмж боловсруулан	90%	90%

							цахим сургалт зохион байгуулна.-100 хувь 3. Цэцэрлэгийн арга зүйчдийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтанд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшүүлэх сургалтыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.-50 хувь Зорилтыг хэрэгжүүлэн ажилласанаар сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийх бэлэн байдал хангагдаж, сургалтын байгууллага үйл ажиллагааны чанарыг үнэлэх, үнэлгээнд суурилсан төлөвлөлт хийж хэрэгжүүлэх ажилд ахиц гарлаа.		
3.1. 1	Нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн чадвар эзэмшүүлэх	-	Ажлын гүйцэтгэл	Туршилтын төлөвлөгөө боловсруулсан	Туршилт зохион байгуулах бэлтгэл	Туршилт зохион байгуулсан	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын	100%	100 %

	хөтөлбөрийн туршилт зохион байгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.				хангасан байна	байна.	хөтөлбөрийн “Нийгэмшил” сургалтын агуулгыг зохиолд суурилсан суралцахуйгаар хүүхдийн хөгжил төлөвшлийг дэмжихэд чиглэсэн туршилтын ажлыг удирдамжийн дагуу Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулж байна. Энэхүү туршилтын ажлын зорилго нь 1.Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн сэтгэл хөдлөл, нийгэмшлийн агуулгаар өөрийн сэтгэл хөдлөлөө ойлгох удирдах, өөрийн болон бусдын сэтгэлийг мэдрэх хүндэтгэх, эерэг харилцаа тогтооход суралцах; 2.Үлгэр зохиолоор дамжуулан сэтгэл		
--	---	--	--	--	----------------	--------	--	--	--

						хөдлөл өөрийн зан үйлийг хянах, шийдвэр гаргах, харилцаа холбоо тогтоож нийгмийн төлөөх хандлага зан төлөвийг төлөвшүүлэх; 3.Үлгэр зохиолын үйл явдлыг асуулт асуух харилцан ярилцах явцад асуудлыг шийдвэрлэх нөхөрсгөөр харилцахад сэтгэл хөдлөлөө удирдах чадварт суралцахад чиглэж байна. Туршилтын ажлын бэлтгэл хангах хүрээнд бага насны хүүхдэд зориулсан Монголын болон гадаадын зохиолчдын зохиол , шилдэг бүтээлүүд, үндэсний ардын аман зохиол зэрэг 100 гаруй зохиол, бүтээлийг сонгон судалгаа хийж, хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцүүлэн нийгмшил		
--	--	--	--	--	--	---	--	--

						сэтгэлийн хөдөлгөөний хөгжилд чухал гэж үзсэн 40 гаруй бүтээлийг сонгон нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 2 цэцэрлэгт турших үйл ажилагааг зохион байгууллаа. Туршин хэрэгжүүлсэн ажлын үр дүнд үндэслэн Зохиолд суурилсан арга зүйг сайжруулж 2024-2025 оны хичээлийн жилд үндэсний хэмжээнд туршин хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна. “Нийгэмшил” хөтөлбөрийн агуулга, арга зүйг шинэчлэн 2-5 насны хүүхдэд зориулсан зохиолыг цахим, интерактив, цаас хэлбэрээр боловсруулан		
--	--	--	--	--	--	---	--	--

							хэрэглэгдэхүүнийг сургалтад нэвтрүүлэх туршилт судалгаа хийснээр Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн Нийгэмшлийн хөтөлбөрийн агуулгыг хүүхэд, гэр бүл, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, “Зохиолд суурилсан суралцахуй” сургалтыг практикт нэвтрүүлэх, багшийн хөгжлийг дэмжих боломжийг нэмэгдүүлнэ. Хавсралт: 1 файл		
3.1.3	Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөн туслах ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөмж боловсруулан цахим сургалт зохион байгуулна.	-	Зөвлөмж, цахим сургалтад хамрагдсан ажилтны тоо.	-	Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөмж боловсруулж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан байна.	Цэцэрлэгийн менежментийг сайжруулах арга зүйн цахим сургалт зохион байгуулж 1410 удирдах ажилтныг хамруулсан	Цэцэрлэгийн менежментэд дэмжлэг үзүүлэх, байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө хийхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2024	100%	100%

						байна.	оны 01 сарын 15-с - 02 сарын 09-ний хооронд 21 аймаг, 9 дүүрэгт зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Цаашид цэцэрлэгийн менежментийг сайжруулах чиглэлээр туршилтын 30 цэцэрлэгийн багш, ажилтнаас авсан менежментийн судалгаанд Монголын хүний нөөцийн хөгжлийн ассоциатай хамтран боловсруулалт хийж, зөвлөмж, гарын авлага боловсруулан ажиллаж байна. Хавсралт: 21 файл		
3.1.3	Цэцэрлэгийн арга зүйчдийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтанд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшүүлэх сургалтыг удирдлага,	-	Сургалтад хамрагдсан арга зүйчийн тоо	Сургалтын модуль боловсруулсан , 25 сургагч багш бэлтгэгдсэн.	Төрийн өмчийн цэцэрлэгийн 934 арга зүйч хамрагдсан байна.	Цэцэрлэгийн арга зүйчдийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтанд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн	"Цэцэрлэгийн арга зүйчдийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтанд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшүүлэх сургалт" -ыг 2023 онд НҮБ -ын	50%	50%

	зохицуулалтаар хангаж ажиллана.					байна.	Хүүхдийн Сангийн санхүүжилтээр МУИС-ийн Сэтгэл судлалын танхимын багш, сэтгэл зүйч нартай хамтран сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, Нийслэлийн Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн арга зүйч нарыг хамруулсан 3 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулж, үндэсний хэмжээнд 25 "Сургагч багш" бэлтгэсэн. Боловсруулсан модулийг дахин сайжруулах, цахим гарын авлага болгох, Сургагч багш нараараа дамжуулан улсын хэмжээнд 930 цэцэрлэгийн арга зүйч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулахаар төлөвлөн, НҮБ-ын Хүүхдийн Санд		
--	---------------------------------	--	--	--	--	--------	---	--	--

						санхүүжүүлэх хүсэлт илгээсэн боловч, боломжгүй гэсэн хариу ирүүлсэн. Иймд өмнө нь боловсруулсан модулийг сайжруулж, цахим ном болгон үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, Боловсролын ерөнхий газрын үндсэн сургалтын агуулгад тусгах, модуль сургалт болгох боломж байгаа эсэх талаар судалгаа хийн ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
3.2.	Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, тэгш хамруулан сургах бодлогын удирдлага зохицуулалтыг хангах	-	-	-	-	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 5 настай хүүхдийг заавал хамруулах, малчдын болон хилчдийн хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх бодлого арга хэмжээг 2023-2024 оны	100%	100%

						хичээлийн жилд төлөвлөн хэрэгжүүлсний үр дүнд сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг тодорхой хувиар нэмэгдүүллээ. Үүнд: Улсын хэмжээнд 3-5 насны 230,536 хүүхэд байгаа ба 2023-2024 оны хичээлийн жилд 213,869 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, хамран сургалт 92,7 хувьд хүрч, өмнөх хичээлийн жилээс 2,3 хувиар өссөн байна. Энэ нь 2023 оны хүрэх үр дүнгийн үзүүлэлтээс 4,2 (88.5) хувиар өссөн байна. 3-5 хүртэлх насны хүүхдийн хамран сургалтыг сүүлийн гурван жилээр авч үзвэл: - 2021-2022 оны хичээлийн жилд хамран сургалт 84,2 хувь байсан бол 2022-2023 оны хичээлийн жилд		
--	--	--	--	--	--	---	--	--

							90,4 хувь болж 6,2 хувиар өссөн байна.		
3.2. 2	Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.	-	Малчдын болон хилчдийн хүүхдийн хамрагдалт	Малчдын хүүхдийн хамрагдалт 73.8хувь, Хилчдийн хүүхдийн хамрагдалт 75,0 хувь	-	Малчдын болон хилчдийн хүүхдийн хамрагдалт тус бүр 1.0 хувиар нэмэгдсэн байна	"Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах талаар 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Улсын хэмжээний малчин өрхийн 0-6 хүртэлх насны хүүхдийн судлагааг газар зүйн байршлаар хийж 2024-2025 оны хичээлийн жилд малчин өрхийн 2-5 насны 51,369 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулахаар хичээлийн жилийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний төсөл	100%	100 %

						боловсруулан ажиллаж байна. Үүний үр дүнд сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтад хамрагдах малчдын хүүхдийн хамрагдалтын хувийг өмнөх оноос 1 хувиар нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. (Хавсралтаар оруулсан файлын код 0503) Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/220, А/269, А/96 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хилчдийн бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах талаар 2023-2025 онд авч хэрэгжүүлэх арга		
--	--	--	--	--	--	--	--	--

						хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба 2023-2024 оны хичээлийн жилд хилчдийн бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд: i) цэцэрлэгийн салбар бүлэг нээх, ii) шинээр гэр цэцэрлэг байгуулах, iii) гэр бүлд суурилсан явуулын сургалтад хамруулах. Үүний үр дүнд 2023-2024 оны хичээлийн жилд 1489 (84,7%) хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, хамран сургалт өнгөрсөн хичээлийн жилээс 9,7 хувиар		
--	--	--	--	--	--	--	--	--

							нэмэгдэж, 170 хүүхдийг шинээр нэмж хамрууллаа. Хил хамгаалах ерөнхий газартай 2023-2024 оны хичээлийн жилд хийсэн ажлын үр дүнг сайжруулах, тогтвортой байдлыг хангах чиглэлээр 7 багц арга хэмжээг хэрэгжүүлэх тухай СӨБХ ийн даргын 2024.5.24-ний өдрийн 16/2221 тоот албан бичгийг хүргүүлэн хамтран ажиллаж байна. Ингэснээр 2024-2025 оны хичээлийн жилд хилчдийн 2-5 насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах боломж нөхцөлийг бүрдүүлж байна. Хавсралт: 3 файл		
3.2.4	Малчдын хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Зөвлөмжийн хэрэгжилт	-	Малчдын хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг	-	Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах,	100%	100%

					авч хэрэгжүүлсэн байна.	сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд "Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах талаар 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан 2 арга хэмжээ Монгол Улсын Засгийн газар - НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2023-2027 оны хамтарсан Улс орны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024-		
--	--	--	--	--	-------------------------------	--	--	--

							2025 оны хамтын ажиллагааны батлагдсан (2024.03 сард) төлөвлөгөөнд тусгагдсан тул НҮБ-ын Хүүхдийн Санд санхүүгийн хүсэлтийг хүргүүлээ. Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргын "Хамтарч ажиллах тухай" 16/1591 тоот албан бичгийг Үндэсний Статистикийн хороонд хүргүүлж, улсын хэмжээнд байгаа 0-6 хүртэлх насны малчин өрхийн хүүхдийн судлагааг хийж, газрын зураг буюу байршлаар төлөвлөлт хийн ажиллаж байна. Улсын хэмжээнд 189.3 мянган малчин өрхийн 2-5 насны 51369 хүүхдийг 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулахаар		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хичээлийн жилийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулан ажиллаж байна. (Хавсралтаар оруулсан файлын код 0503.) Хавсралт: 2 файл		
3.3.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах	-	-	-	-		Арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний БШУЯ-ны хариуцах болон бусад яам, харьяа байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх 12 ажил арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна	70%	70%
3.3. 6	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, зохицуулалтыг ханган ажиллана.	-	Төлөвлөсөн үйл ажилагааны хэрэгжилт	2023 онд төлөвлөсөн 11 арга хэмжээний биелэлт 100 хувь	-	2024 онд төлөвлөгдсөн 12 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	БШУ-ны сайд, ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалаар “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ” батлагдсан. Тус арга хэмжээг 2024	70%	70%

						онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг орон тооны бус үндэсний зөвлөлийн даргаар /ХНХ-ын дэд сайд/ батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний БШУЯ-ны хариуцах болон бусад яам, харьяа байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх 4 ажил арга хэмжээний хэрэгжилт 90 хувьтай байна. /2024 оны эцэст 100 хувьд хүрнэ, эдгээр арга хэмжээ тус бүрийн дэлгэрэнгүй тайланг хавсралтад орууллаа./ Төлөвлөгдсөн арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрлээ. Үүнд: 1. Монгол Улсын бага насны		
--	--	--	--	--	--	---	--	--

						хүүхдийн хөгжлийг дэмжих үндэсний болон орон нутгийн орон тооны бус зөвлөлүүд улсын хэмжээнд бүрэн байгуулагдаж, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын салбарын байгууллагуудын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг аймаг, нийслэл, дүүргийн түвшинд боловсруулан баталж хэрэгжүүлснээр нийгмийн үйлчилгээний салбарын уялдаа, удирдлага зохицуулалт хангагдаж байна. 2. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн орон тооны бус зөвлөлийн гишүүдийг чадавхжуулахад чиглэсэн үе шаттай үйл ажиллагааг		
--	--	--	--	--	--	--	--	--

						зохион байгуулснаар бодлогын зорилт үр дүнтэй хэрэгжих боломж бүрдэж байна. 3. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих олон нийтийн 25 байгууллагыг нэгтгэсэн үндэсний сүлжээ албан ёсоор байгуулагдаж, үйл ажиллагааны хүрээ нэмэгдсэнээр хүүхдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гарч байна. 4.Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийг чадавхжуулахад чиглэсэн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлж ажилласнаар хүүхдийн эрүүл мэнд, хамгаалал, хөгжил боловсролын байдалд эерэг нөлөөлөл бий болж, үйлчилгээ		
--	--	--	--	--	--	---	--	--

							гэр бүлд ойртлоо. 5. Бага насны хүүхдийн асаргаа, хамгаалал, хөгжил, боловсролын үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх хөтөлбөр батлагдсанаар хүүхдэд үзүүлэх олон хувилбарт үйлчилгээг чанартай хүргэх боломж нөхцөл бүрдэнэ. Хавсралт: 3 файл		
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
4.1.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн гүйцэтгэлийг төлөвлөх, тайлагнах	-	Гүйцэтгэлийн хувь	-	Шийдвэрийн хангасан байна	хэрэгжилтийг	Сургуулийн өмнөх боловсролын салбарын чиглэлээр хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт туссан ажил арга хэмжээний биелэлтийг хугацаанд тухай бүр бүрэн тайлагнаж ажиллалаа. 2. Сургуулийн өмнөх боловсролын хэлтсээс 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт	100%	100%

							17 ажил, арга хэмжээг хагас жилийн байдлаар 91,7 хувьтай хийж гүйцэтгэлээ. /11 арга хэмжээ 100 хувь, 3 арга хэмжээ 90 хувь, 2 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувь байна/ 2. Дээд албан тушаалтнаас өгсөн 7, шуурхай хурлаас гарсан 9 үүрэг даалгаврыг бүрэн биелүүлж ажиллалаа.		
4.1.1	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	-	Гүйцэтгэлийн хувь	-	Хууль, тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна	Хууль, тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийн сар бүр гаргаж тайлагналаа. Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллагын /БЕГ, БСҮХ, БҮТ/ сургуулийн өмнөх боловсролын салбартай холбогдох албан тушаалд ажиллаж	100%	100%

						буй мэргэжилтнүүдийг чадвахжуулах сургалтын хөтөлбөрийн дагуу 4 цагийн агуулга бүхий дадлага ажилд суурилсан сургалтыг зохион байгууллаа. Мэргэжилтнүүд сургалтад хамрагдсанаар сургуулийн өмнөх боловсролын салбарт хэрэгжүүлэх бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах чиглэлээр мэдээллээр хангагдаж цаашид ажилдаа тусган хэрэгжүүлэх чадвартай боллоо. Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт байрлаж, сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа эрхлэн явуулж буй гадаадын хөрөнгө		
--	--	--	--	--	--	---	--	--

						оруулалттай “Хүүхдийн баясгалан”, "Баянхошуу сейнтпоул" цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаа, сургалтын орчны стандарт шаардлага хангаж буй байдалтай танилцаад сургалтын чанарыг сайжруулах, хүүхдийн суралцах орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг ханган ажиллах талаар дараах зөвлөмжийг яамны 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн албан бичгээр хүргүүллээ. Монголын багш нарын VIII их хурал, Сургуулийн өмнөх боловсролын салбар хуралдааныг амжилттай зохион байгууллаа. Зөвшөөрлийн цахим системийн	
--	--	--	--	--	--	--	--

							хөгжүүлэлтэй холбогдох бодлогын даалгавар боловсруулан, гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэгт зөвшөөрөл цахимаар олгох, хугацаа сунгах ажлын бэлтгэлийг хангаж, 2 цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг сунгах ажлыг хийж байна. Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа эрхлэн явуулах зөвшөөрөлтэй 9 байгууллагын мэдээллийг licence.mn зөвшөөрлийн нэгдсэн системд бүртгэж батлагаажууллааа .		
4.1.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд	-	Хүлээлгэн өгсөн архивын нэгж Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт	-	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан архивын баримт	Иргэд , байгууллагаас ирүүлсэн албан бичгийг хуулийн хүрээнд	Сургуулийн өмнөх боловсролын салбарын хүрээнд иргэн, байгууллагаас 2024 оны 06 дугаар	100%	100 %

	гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх				бүрдүүлж хүлээлгэн өгсөн байна. Иргэд , байгууллагаас ирүүлсэн албан бичгийг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна.	шийдвэрлэсэн байна.	сарын 1-ний өдрийн байдлаар ирүүлсэн 20 албан бичгийг шийдвэрлэж, 18 албан бичгийг хүргүүллээ. Хариуцсан албан чиг үүргийн хүрээнд архивын ХХНЖ-д заасан 8 нэгж, 2 гарын авлага /ном/-ыг архивчид хүлээлгэн өглөө.		
--	--	--	--	--	--	---------------------	--	--	--

Үнэлсэн:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(02H00)